

Article

The necessity and requirement for establishing legal regulations on the transplantation of cells, tissues, and organs from deceased donors

Khishigmunkh Osorjin^{1*}, Khuslen Bayar-Erdene²

¹Department of Private Law, School of Law, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

²Department of Private Law, School of Law, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: khishigmunkh@otgontenger.edu.mn

 <https://orcid.org/0009-0001-2992-7171>

Received: 20 March 2026. Accepted: 20 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

Since the Donor Law was first adopted in Mongolia in 2000 and revised in 2018, a basic system has been established to regulate the collection and transplantation of cells, tissues, and organs. To date, 278 potential brain-dead donors have been identified, and 45 kidney, 27 liver, and 173 tendon transplants have been performed through 31 actual donors, saving 72 lives and improving the quality of life of 173 people. However, more than 1,000 citizens are registered on the donor waiting list, indicating that the availability of organs and tissues is insufficient and poses a serious risk to the lives of citizens. According to statistics, as of 2024, 83 percent of kidney transplants and 93 percent of liver transplants will be performed by living donors, which poses a risk to the health and life of donors and creates an urgent need to improve the regulation and control of organ transplantation. Therefore, there is a real need to develop the system for obtaining tissues, cells, and organs from deceased donors in line with national customs and social attitudes, and to improve the legal environment.

Keywords: deceased donor, recipient, organ transplant



© 2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Амьгүй донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгах эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага

Осоржингийн *Хишигмөнх*¹, Баяр-Эрдэнийн *Хүслэн*²

¹Доктор(Ph.D), Хувийн эрхзүйн тэнхим, Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Улаанбаатар хот, Монгол улс

²Магистрант, Хувийн эрхзүйн тэнхим, Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Улаанбаатар хот, Монгол улс

Хураангуй

Монгол Улсад Донорын тухай хууль анх 2000 онд батлагдаж, 2018 онд шинэчлэгдэж батлагдсанаас хойш эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах суурь тогтолцоо бүрдэж, одоогийн байдлаар 278 тархины үхэлтэй боломжит донор илрүүлснээс 31 бодит донороор дамжуулан 27 элэг, 45 бөөр, 173 шөрмөс шилжүүлэн суулгах мэс заслыг гүйцэтгэж, 72 хүний амь насыг аварч, 173 хүний амьдралын чанарыг сайжруулаад байна. Гэвч донорын хүлээлгийн жагсаалтад 1000 гаруй иргэн бүртгэлтэй байгаа нь эрхтэн, эдийн олдоц хангалтгүй, иргэдийн амь насанд ноцтой эрсдэл учирч байгааг илтгэж байна. Статистик мэдээллээс үзэхэд 2024 оны байдлаар бөөр шилжүүлэн суулгах хагалгааны 83 хувь, элэг шилжүүлэн суулгах хагалгааны 93 хувийг амьд донороос гүйцэтгэж байгаа нь донорын эрүүл мэнд, амь насанд эрсдэл учруулахын зэрэгцээ эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох, хяналтыг сайжруулах зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Иймд амьгүй донороос эд, эс, эрхтэн авах тогтолцоог үндэсний ёс заншил, нийгмийн хандлагатай уялдуулан хөгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бодитоор тулгамдаж байна.

Түлхүүр үгс: амьгүй донор, реципиент, эрхтэн шилжүүлэн суулгах

Удиртгал

Монгол Улсад донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгах эмчилгээний эрэлт хэрэгцээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа хэдий ч донорын олдоц, ялангуяа амьгүй донороос авах, шилжүүлж буй байдал цөөн байна. Энэ нь амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ давамгайлж, донорын эрүүл мэнд, амь насанд эрсдэл учруулахын зэрэгцээ реципиентүүд хүлээлгийн жагсаалтад олон жил хүлээх нөхцөл үүссэн. Иймээс амьгүй донороос эд эрхтэн шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох практик хэрэгцээ шаардлагатай юм.

Энэхүү судалгаагаар бид Монгол Улсад амьгүй донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгахтай холбогдох эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, тулгамдсан асуудлыг оновчтой тодорхойлох, цаашид шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх зорилготой. Судалгааг хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг харьцуулалтын арга, түүхчлэх арга, анализ, синтезийн арга зэрэг аргуудыг хэрэглэсэн болно. Тухайлбал, харьцуулалтын аргын хүрээнд өөрийн улсын эрх зүйн зохицуулалтыг гадаадын зарим улс болох Испани, АНУ, БНСУ улстай харьцуулан судалсан. Түүхчлэх аргын хүрээнд одоогийн эрх зүйн зохицуулалтаас өмнө үйлчилж байсан хууль тогтоомжийн заалтуудыг судалсан бөгөөд эрх зүйн зохицуулалтыг задлан шинжлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлохдоо нэгтгэн дүгнэх аргуудыг ихэвчлэн ашигласан.

Донорын тухай хуулийг хамгийн анх 2000 онд баталж, 2018 онд шинэчлэн найруулснаар амьгүй донор, тархины үхэл зэрэг суурь ойлголтуудыг хуульчилсан ч амьгүй донортой холбоотой нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байна. Тухайлбал, донорын зөвшөөрлийн хэлбэр тодорхой бус, нас барагчийн хүсэл зориг болон гэр бүлийн шийдвэр зөрчилдөх тохиолдолд аль нь давуу үйлчлэхийг зохицуулаагүй зэрэг эрх зүйн хийдэл ажиглагдаж байна. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслөөр салбарын онцлогт нийцсэн бие даасан зохицуулалтыг бий болгохыг зорьж буй ч зарим зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

Олон улсын сайн туршлагын хувьд эрхтэн шилжүүлэн суулгах тогтолцоог зөвхөн зөвшөөрлийн хэлбэр (opt-in, opt-out)-ээс хамаарахгүй бөгөөд институцийн нэгдсэн зохион байгуулалт, ил тод хяналтын тогтолцоо, шударга хуваарилалт, олон нийтийн итгэлцэл чухал үүрэгтэй байна. Ялангуяа Испани, АНУ-ын туршлага нь төвлөрсөн удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, алгоритмд суурилсан шийдвэр гаргалт нь донорын тоог нэмэгдүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтойг харуулж байна.

Иймд Монгол Улсад амьгүй донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэх үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд олон улсын жишигт нийцсэн, хүний эрх, ёс зүйн зарчмыг хангасан эрх зүйн цогц зохицуулалтыг бүрдүүлэх, институцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь олон хүнд амьдрал бэлэглэх, хууль ёсны эд эрхтэнг хяналттай авах, шилжүүлэх асуудал нэг мөр болох практик ач холбогдолтой болно.

Амьгүй донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгах эрх зүйн зохицуулалт

Дэлхийн чиг хандлагаар бусад улс орнууд амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах нь илүү үр дүнтэй гэж үздэг байна. Энэ нь амьд хүнд эрүүл мэндийн эрсдэл үүсгэхгүйгээс

гадна, хагалгааны дараа донорыг эдгээх хянах шаардлагагүй, гуравдугаарт элэгний хувь бүтэн элэг тавигддаг, дөрөвдүгээрт хагалгааны техникийн хувьд хөнгөн байдаг гэж мэргэжилтнүүд үздэг ажээ. “Монгол Улсад гэнэтийн ослоор нэг жилд 600 гаруй хүн, тархинд цус харвах өвчнөөр 3000 гаруй хүн нас бардаг” (Донорын эрэлд, 2024) нь амьгүй донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэх боломж байгааг харуулна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (WHO) дэмжлэгтэй ажилладаг "Эрхтэн шилжүүлэн суулгах дэлхийн ажиглалтын төв" (Global Observatory on Donation and Transplantation - GODT)-ийн 2024 оны тайлангаар дэлхийн 92 улс доод тал нь нэг төрлийн эрхтэн (бөөр, элэг, зүрх г.м) шилжүүлэн суулгах мэс заслыг тогтмол гүйцэтгэж байна. 2024 оны байдлаар дэлхийн улс орнууд нийт 173727 эрхтэн шилжүүлэх мэс засал хийгдсэнээс 47180 нь амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгасан нь өмнөх оныхоос хоёр хувиар өссөн үзүүлэлттэй байна (Friederike Martin, 2026). Тэдгээрийн 90 улс оронд энэ харилцааг зохицуулсан бие даасан хуультай байдаг ба Монгол улсын хувьд эдийн засаг, санхүүгийн боломж бусад орнуудаас харьцангуй хязгаарлагдмал байдалтай хэдий ч эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгах эмчилгээг цогцоор нь амжилттай хэрэгжүүлдэг цөөхөн улсуудын нэг юм.

“Монгол улсад эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийснээс хойш 2023 оны 12 дугаар сарыг хүртэл Улсын Нэгдүгээр төв эмнэлэгт 331 иргэнд бөөр (41 иргэнд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгасан), 234 иргэнд элэг (12 иргэнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан), Хавдар судлалын үндэсний төвд нийт 118 хүнд элэг шилжүүлэн суулгах (эдгээрээс 10 хүнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан) тус тус амжилттай шилжүүлэн суулгах эмчилгээг хийсэн байна...Одоогоор 24 иргэнд ясны чөмөгний үүдэл эс, 24 иргэнд нүдний эвэрлэг, 1735 иргэнд арьс, 150 гаруй иргэнд шөрмөс, 974 иргэнд үр шилжүүлсэн суулгах эмчилгээг хийж 442 амьд хүүхэд төрсөн байна.” (УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн, С.Одонтуяа, Ц.Туваан нар Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай анхдагч хуулийн төслийг өргөн мэдүүллээ., 2024).

“Хүний эс, эд, эрхтэн гэж хүний эрхтэн, эрхтний хэсэг, эс болон эдийн нийлмэл бүрдлийг хэлнэ” (Донорын тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг, 2018). Хуулиар донорыг амьд болон амьгүй донор гэж ангилсан. “Амьд донор гэж өөрийн болон хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан эс, эд, эрхтэн болон эрхтний хэсгээ сайн дураар өгөгчийг” (Донорын тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг, 2018) хэлнэ. “Амьгүй донор гэж тархи бүрэн үхжиж, үйл ажиллагаа эргэшгүй алдагдсан, нас барсан нь тогтоогдсоны дараа үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа зарим эс, эд, эрхтнийг шилжүүлэн

суулгахаар авч болох цогцсыг” (Донорын тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэг, 2018) хэлнэ хэмээн тодорхойлсон.

Донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Донорын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн сайдын А/198 дугаар тушаал болон түүний хавсралт болох Донороос цус, эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, шилжүүлэн суулгах, устгах, журам зэрэг бусад долоон хавсралтаар тус тус зохицуулж байна.

Амьгүй донор гэж “тархины үхэлтэй нь тогтоогдсон донороос эс, эд, эрхтэн авах” (Донорын тухай хууль, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 2018)-ыг хэлнэ. “Амьгүй донороос эс, эд, эрхтэн авахдаа нас барагчийн гэрээслэл, түүний төрсөн эцэг, эх, эхнэр, нөхөр, хамтын амьдрал бүхий гэр бүлийн насанд хүрсэн гишүүний зөвшөөрлийг авна. Амьгүй донороос эс, эд, эрхтэн авахдаа зүрхний үйл ажиллагааг зохиомолоор удирдана” (Донорын тухай хууль, 15 дугаар зүйлийн 15.2-15.3 дахь хэсгүүд, 2018) гэж хуульчилсан. Донорын үйл ажиллагаанд “хууль, хүний эрхийг дээдлэх, хүмүүнлэг, энэрэнгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, аюулгүй байдлыг хангах, хүний эмзэг мэдээллийг хамгаалах” (Донорын тухай хууль, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 2018) зарчим баримтлахаас гадна “донорын үйл ажиллагааг ашиг орлогын эх үүсвэр болгох, тулган шаардах, худалдахыг хориглоно” (Донорын тухай хууль, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, 2018). Хуульд тусгасан уг зарчмууд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зарчимтай нийцэж байгаа хэдий ч эс, эд, эрхтэн хүлээн жагсаалтад байгаа иргэдэд хэрхэн хувиарлах, нээлттэй систем бий болгох, хяналт тавих, санхүүжилтийг нээлттэй байлгах чухал зохицуулалтууд тодорхой бус ерөнхий байна.

“Монгол Улсын 21 насанд хүрсэн иргэн эрхтнээ бусдад шилжүүлэн суулгахыг зөвшөөрсөн шийдвэрээ өөрийн харьяа болон аль ч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад гарын үсгээр баталгаажуулан өгч, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ, цахим картад тэмдэглүүлж болно” (Донорын тухай хууль, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 2018). Мөн тархины үхэлтэй гэж тогтоогдсон амьгүй донороос “нас барагчийн гэрээслэл, түүний төрсөн эцэг, эх, эхнэр, нөхөр, хамтын амьдрал бүхий гэр бүлийн насанд хүрсэн гишүүний зөвшөөрлийг бичгээр” (Донорын тухай хууль, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 2018) авснаар эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах боломжтой гэжээ. Үүнд хэрвээ нас барагчийн гэрээслэл болон хуульд заасан гэр бүлийн гишүүний зөвшөөрөл хоорондоо зөрчилдвөл аль нь илүү давуу эрхтэй байхыг тодорхой тусгаагүй байна.

Донорын тухай 2018 оны хууль нь өмнөх Донорын тухай 2000 оны хуультай нь харьцуулахад амьгүй донор болон тархины үхлийн талаар томъёолж, амьгүй донороос эс, эд, эрхтэн авах суурь зарчим болон ерөнхий үйл ажиллагааг хуульчилж өгсөн ч хэдий цусны донор болон амьд донороос эс, эд, эрхтэн авах болон шилжүүлэн суулгах харилцааг илүүтэй зохицуулжээ. Амьгүй донорын талаар олон нийтэд ойлголт өгөх, түүний тоог нэмэгдүүлэх тал дээр тусгайлан зохицуулсан заалт байхгүйгээс гадна амьгүй донор болох зөвшөөрлийн явц нь ойлгомжгүй, нарийвчилсан зохицуулалтгүй хэвээр байна.

Үүнийг тодорхой болгох, амьд донороос илүү амьгүй донороос эс, эд, эрхтэн шилжүүлэн авах хуулийн төслийг хууль санаачлагч боловсруулан өргөн барьсан (УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн, С.Одонтуяа, Ц.Туваан нар Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай анхдагч хуулийн төслийг өргөн мэдүүллээ., 2024). Одоо мөрдөгдөж буй Донорын тухай хуулинд цус, эс, эд, эрхтэн, үр шилжүүлэн суулгахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан байдаг бол энэ хуулийн төсөл нь Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай болон цусны донорын тухай бие даасан тусдаа хуулийн төслийг өргөн барьснаараа онцлогтой байгаа юм.

Хүснэгт 1. Донорын тухай хууль болон Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн бүлгийн харьцуулалт

	Донорын тухай хууль 2018 он	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл
	6 бүлэг, 24 зүйлтэй	5 бүлэг, 26 зүйлтэй
Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг	Донорын үйл ажиллагааны удирдлага, бүтэц, зохион байгуулалт	Реципиент болон амьд донорыг сонгох, тэдгээрийн эрх үүрэг, амьгүй донорыг илрүүлэх, бүртгэх
Гуравдугаар бүлэг	Донор, реципиент, эрүүл мэндийн байгууллага, ажилтанд тавигдах шаардлага	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ
Дөрөвдүгээр бүлэг	Донороос цус, эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны удирдлага, бүтэц, зохион байгуулалт
Тавдугаар бүлэг	Цусны донорын эгнээг өргөжүүлэх	Бусад зүйл
Зургаадугаар бүлэг	Бусад зүйл	

Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод эсийн донор, реципиент эмнэлэг, донор эмнэлэг, эд, эсийн сан, биологийн эцэг, эх зэрэг нэр томъёо шинээр нэмэгдсэн байна. Мөн шилжүүлэн суулгалт гэх нэр томъёог шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ болон эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ гэж задлан тайлбарласан байна. Эрхтэн, эд, эс

шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд баримтлах зарчимд мөн зарим өөрчлөлт орж аюулгүй байдлыг хангах гэсэн зарчмыг хасаж мэдээллийг танилцуулж зөвшөөрөл авсан байх гэсэн зарчим нэмэгджээ. Донороос эд, эс, эрхтэн авахдаа зөвшөөрлийн зохицуулалтыг зарчим хэсэгт тусгаж өгсөн нь учирч болох эрсдэлээс хамгаалах зарчим байна. Гэвч аюулгүй байдлыг хангах зарчим нь ДЭМБ-ээс гаргасан Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах удирдамж 11 зарчмуудад (WHO, 2010) үндэслэгдсэн байсан тул хасах нь зохимжгүй гэж үзэж байна.

Реципиентэд тавигдах шаардлагыг илүү нарийвчлан тусгаж өгсөн ба гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд тавигдах шаардлагыг тусгаж өгснөөрөө шинэлэг болжээ. Мөн реципиентийн эрх, үүргийг тусгасан байна. Донорын тухай хуульд донорт тавигдах шаардлага, эрх, үүргийг цусны донор эсвэл амьд донор хэмээн ялгалгүй ерөнхийлөн тусгаж өгсөн бол энэ хуулийн төсөл цусны донортой холбоотой тусдаа хуулийн төсөл өргөн барьсантай холбогдуулан амьд донорт тавигдах шаардлага, эрх, үүрэг болон амьгүй донорт тавигдах шаардлагыг нарийвчлан тусгажээ.

Амьгүй донорт тавигдах шаардлагад тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэлтэй болох нь тогтоогдсон амьгүй донорын “эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан эцэг, эх, төрсөн хүүхэд, төрсөн ах, эгч, дүү гэсэн дарааллаар гэр бүлийн гишүүдийн 3 хүртэлх гишүүнээс зөвшөөрлийг бичгээр” (Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай, Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 2025) авах хэмээн дарааллыг нарийн тогтоож өгчээ. Гэсэн хэдий ч хэрвээ нас барагчийн гэрээслэл болон хуульд заасан гэр бүлийн гишүүний зөвшөөрөл хоорондоо зөрчилдвөл аль нь илүү давуу эрхтэй байхыг тусгаагүй хэвээр байна. Мөн “амьгүй донорын эрхтэн, эд, эсийг зөвхөн Монгол Улсын иргэнд шилжүүлэн суулгана” (Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай, uih.mn, 2025) гэсэн нь донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгахаас үүдэх хүний наймаа, хүний эс, эд, эрхтний хууль бус худалдаа, эрхтэн шилжүүлэн суулгах зорилгоор гадаад улс руу аялах аяллын эсрэг хамтран ажиллахаар 2008 оны дэлхийн 145 орны эрүүл мэндийн сайд нарын уулзалтаар гарын үсэг зурж баталсан Declaration of Istanbul буюу Станбулын тунхаглалд Монгол улс 2018 оны үед Испани улсад зохион байгуулагдсан дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэгээс зохион байгуулагдсан 27 дугаар их хуралд оролцох үедээ элсэн орсон байдагтай (Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай, uih.mn, 2025, хууд. 3) холбоотой чухал зохицуулалт болсон байна.

Хуулийн төсөлд “18 хүртэлх насны амьгүй донорын эрхтэн, эд, эсийг хүүхэд, насанд хүрсэн хүн гэсэн дарааллаар” (Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай, uih.mn, 2025)

шилжүүлэн суулгахаар зохицуулжээ. Гадны нөлөөтэй амьгүй донороос эрхтэн, эд авах тохиолдлыг мөн зохицуулахаар тусгасан байна. Үүнд амьгүй донорт тавигдах шаардлагыг 18 хүртэлх нас гэж заасан ч донор болохоо илэрхийлэх насыг 21 гэж заасан нь эргэлзээ төрүүлж, цаашид хуулийн хэрэгжилт практикт зөрчил үүсгэж болзошгүй юм.

Донор болох хүсэлтээ цахимаар болон өөрийн биеэр баталгаажуулах боломжтой (Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай, uih.mn, 2025) гэж тусгаснаар амьгүй донорын тоог нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

“Амьгүй донороос эрхтэн, эд, эсийг авах тохиолдолд шилжүүлэн суулгах эрхтэн, эд, эсийн талаар түүний гэр бүлийн гишүүдэд урьдчилан танилцуулах бөгөөд зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эсийг авахыг хориглоно” (Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай, 2025) гэснээр ирээдүйд учирч болох үл ойлголцол болон эрсдлээс урьдчилан сэргийлэх чухал заалт болсон байна.

Түүнчлэн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын амьгүй донорыг тандах, судлах, илрүүлэх, хуваарилах, зохицуулах, зөвшөөрөл авах зэрэг зохицуулалттай холбоотой эрх, үүрэг болон амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмжийг нарийвчлан тусгасан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ” (Монгол Улсын Үндсэн Хууль, 1992). Эрүүл мэндийн тухай хуулиар “донорын цус, цусан бүтээгдэхүүн, эс, эд, эрхтнийг эмчилгээний зориулалтаар авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах, импортлох, экспортлох асуудлыг хуулиар зохицуулахаар” (Эрүүл мэндийн тухай хууль, 2011) тус тус заасан.

Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтын сайн туршлага, амьгүй донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгах эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага амьгүй донороос эрхтэн шилжүүлэхийг уриалж, амьд донороос аль болох татгалзахыг зөвлөдөг. Монгол Улсын хувьд Донорын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тархины үхэлтэй нь тогтоогдсон донорын ар гэрээс бичгээр зөвшөөрөл өгсөн тохиолдолд эс, эд, эрхтнийг нь хүлээлгийн жагсаалт дахь өвчтөнүүдээс шаардлага хангасан, таарамжтай хүмүүст шилжүүлэн суулгах зохицуулалт орсон хэдий ч донор хүлээсэн иргэд олон байгаа нь одоогийн зохицуулалтыг практик хэрэгцээ, шаардлагатай

уялдуулан сайжруулах нь чухал байна. Бусад улсын хувьд эрх зүйн орчныг тодорхой түвшинд бүрдүүлж өгснөөр шийдвэрлэж буй практикууд байна. Сэдвийн хүрээнд сайн туршлага болохуйц эрх зүйн зохицуулалтай Испани, Америкийн нэгдсэн Улс, Бүгд найрамдах Солонгос улсыг харьцуулан судалсан болно.

Испани улс “зөөлөн opt-out” буюу зөвшөөрсөнд тооцох тогтолцоог хэрэгжүүлдэг бөгөөд 1979 оны Испанийн эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулиар тархины үхлийг хуульчилж, амьгүй донороос эрхтэн авах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Үндэсний трансплант байгууллага (ONT)-ын төвлөрсөн зохицуулалт, мөн зүрхний үйл ажиллагаа зогссоны дараах донор (DCD)-ын өргөн хэрэглээ нь донорын түвшинг дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүргэхэд чухал нөлөө үзүүлсэн. Хэдийгээр хуульд зөвшөөрсөнд тооцох зарчим үйлчилдэг ч практикт гэр бүлийн зөвшөөрлийг зайлшгүй харгалзан үздэг онцлогтой (Organ donation: lessons from the Spanish model, 2024).

АНУ нь “opt-in” буюу ил тод зөвшөөрлийн тогтолцоог хэрэгжүүлдэг бөгөөд иргэн амьдадаа донор болох шийдвэрээ бүртгүүлэх шаардлагатай. 1984 оны Үндэсний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль, 2006 оны Анатомины бэлэглэлийн нэгдсэн хууль болон 1981 оны үхлийг тодорхойлох нэгдсэн хууль зэрэг хуулиудаар эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний сүлжээ (OPTN) болон Эрхтэн хуваарилалтын нэгдсэн сүлжээ (UNOS)-ээр дамжуулан эрхтэн хуваарилалтыг төвлөрсөн, алгоритмд суурилсан байдлаар хэрэгжүүлдэг нь ил тод, шударга байдлыг хангадаг. Мөн АНУ-д амьгүй донорын төрөлд тархины үхэлтэй донор (brain death donor) болон зүрхний үйл ажиллагаа зогссоны дараах донор (DCD)-ыг аль аль нь хуульчилж, өргөн хэрэглэдэг нь амьгүй донорын тоог нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болдог. (UDDA, 1981, pp. 6-7) Ялангуяа DCD нь донорын нөөцийг нэмэгдүүлэх чухал арга хэрэгсэл болж байна. Донорын зөвшөөрөл нь хууль зүйн хүчинтэй бөгөөд зарим тохиолдолд гэр бүлийн шийдвэрээс давуу үйлчилдэг. Мөн эрхтэн худалдахыг хатуу хориглосон нь хүний эрхийг хамгаалах чухал механизм болдог.

БНСУ нь мөн opt-in тогтолцоог хэрэгжүүлдэг бөгөөд 1999 оны Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль (OTA, 1999)-аар эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн. Тус улсад тархины үхлийг хуульчилж, донор тодорхойлох, зөвшөөрөл авах, эрхтэн хуваарилах үйл явцыг нарийвчлан зохицуулсан. Солонгосын эрхтэн хуваарилах нэгдсэн сүлжээ (KONOS) байгууллага нь донорын бүртгэл, хуваарилалтыг төвлөрсөн байдлаар удирддаг. Гэвч нийгэм, соёл, гэр бүлийн шийдвэр давамгайлах хандлагаас шалтгаалан донорын түвшин харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна (Improving self-sufficiency in organ transplantation in Korea, 2021).

Эдгээр улсын туршлагаас харахад зөвшөөрлийн тогтолцоо (opt-in, opt-out) нь чухал боловч дангаараа хангалтгүй бөгөөд институцийн үр ашигтай зохион байгуулалт, ил тод байдал, олон нийтийн ойлголт, соёлын хүчин зүйлс эрхтэн шилжүүлэн суулгалтын амжилтад шийдвэрлэх үүрэгтэй байна.

Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн авах нь амьд донорын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл иргэнтэй байх үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхой хэмжээгээр нийцэж буйг дурьдах нь зүйтэй. Мөн амьд донор нь үнэ төлбөргүй эс, эд, эрхтэнээ шилжүүлэх хуулийн зохицуулалтай хэдий ч хууль бусаар төлбөртэйгээр эс, эд, эрхтэнээ шилжүүлэх тохиолдол байгааг олон нийтийн цахим орчин дэх зар, мэдээллүүдээс харж болохоор байна.

Амьгүй донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгах үйл ажиллагаа нь анагаах ухааны хувьд өндөр ач холбогдолтой боловч эрх зүй, ёс зүй, нийгмийн олон талт асуудалтай салшгүй холбоотой. Энэхүү ажлыг эрх зүйн талаас илүү анхаарч тулгамдаж буй асуудал болон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

1. Донорын хомсдол нь хамгийн том тулгамдсан асуудал хэвээр байна. Олон улсад эрхтэн шилжүүлэн суулгах хэрэгцээ өндөр боловч хангалт бага байгаа нь донорын зөвшөөрлийн тогтолцоо, олон нийтийн ойлголт, итгэлцэлтэй шууд холбоотой. Ялангуяа opt-in тогтолцоотой орнуудад иргэдийн идэвхтэй бүртгэл сул байдаг нь донорын нөөцийг хязгаарлаж байна.
2. Тархины үхлийг тодорхойлох, хүлээн зөвшөөрөх асуудал чухал сорилт болдог. Эмнэлзүйн болон эрх зүйн тодорхой бус байдал, мөн иргэдийн ойлголт дутмаг байдал нь амьгүй донороос эрхтэн авах үйл явцыг хүндрүүлдэг.
3. Ёс зүйн болон хүний эрхийн асуудал хөндөгддөг. Донорын зөвшөөрөл үнэхээр сайн дурын эсэх, гэр бүлийн оролцооны хэмжээ, мөн эмзэг бүлгийг хамгаалах асуудал чухал байр суурь эзэлдэг. Үүнтэй холбоотойгоор эрхтэн худалдах, зуучлах зэрэг хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх шаардлага бий.
4. Институцийн зохион байгуулалт, ил тод байдлын сул тал нь итгэлцэлд сөргөөр нөлөөлдөг. Хэрэв эрхтэн хуваарилалт шударга бус, ил тод бус гэж үзвэл олон нийт донор болохоос татгалзах хандлага нэмэгддэг. Мөн донор болох хүсэлтээ

илэрхийлсэн субъектын хувийн нууцыг хамгаалах зохицуулалт байхгүй байгаа нь иргэдийн итгэлцэл сул байхад нөлөөтэй байна.

5. Соёл, шашны нөлөө нь донорын тогтолцоонд чухал үүрэгтэй. Зарим нийгэмд цогцсын бүрэн бүтэн байдлыг хадгалах уламжлал давамгайлдаг нь донорын зөвшөөрөл өгөхөд саад болдог.

Донорын зөвшөөрлийн тогтолцоог тодорхой, ойлгомжтой болгох, донор болон реципиентийн эрхийг хамгаалах, ёс зүйн зарчмыг баталгаажуулах, эрхтэн хуваарилалтын ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэх, төвлөрсөн мэдээллийн систем нэвтрүүлэх, эрхтэн худалдахыг хатуу хориглож, хяналтын механизм бий болгох, олон нийтийн боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэх, итгэлцлийг бэхжүүлэх бодлого хэрэгжүүлэх, эмнэлгийн байгууллагуудын чадавх, мэргэжилтний бэлтгэлийг сайжруулж, эмнэлгийн ажилтны мэргэжлийн ёс зүйг чандлан сахих зэрэг амьгүй донороос эс, эд, эрхтэн авах, шилжүүлэн суулгах бие даасан эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлага тулгараад байгаа юм.

Дүгнэлт, санал

Донорын тухай 2018 оны хууль нь цус, эс, эд, эрхтний донорын харилцааг нэгтгэн зохицуулсан суурь баримт бичиг болохын хувьд "амьгүй донор", "тархины үхэл" зэрэг нэр, томъёог хуульчилж цөөнгүй хүнд амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах боломжийг олгосон. Одоогийн хуулийн зохицуулалт нь өмнөх хуулийн нэгэн адил амьд донор болон цусны донортой холбоотой зохицуулалтууд дээр илүү төвлөрсөн, амьгүй донортой холбоотой заалтууд нь ерөнхий шинжтэй, нарийвчилсан зохицуулалт хангалтгүйгээс практикт тодорхойгүй маргаануудыг дагуулсан. Иймд одоогийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагатай байна.

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд хуулийн төсөл өргөн баригдсан хэдий ч түүнээс хойш нэг жил өнгөрч донор хүлээх иргэдийн тоо нэмэгдэж буй нь төрөөс иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах үндсэн эрхийг бодит байдал дээр хангалттай биелүүлж чадахгүй байгааг харуулж байна.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл нь практик хэрэгцээнд нийцсэн, цаг үеэ олсон чухал зохицуулалтуудыг агуулсан болно. Уг төсөл нь цусны донорын харилцааг тусгаарлаж, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний онцлогт тохирсон бие даасан зохицуулалт бий болгохыг зорьсноороо ач холбогдолтой юм.

Испани, АНУ, БНСУ-ын туршлагаас үзэхэд амжилттай тогтолцооны үндэс нь зөвхөн хууль эрх зүйн хэлбэр (opt-in/opt-out) биш, харин институцийн чадавх, мэдээллийн нэгдсэн сүлжээ, ил тод хяналт болон олон нийтийн итгэлцэл юм. Испанийн ONT болон АНУ-ын UNOS зэрэг байгууллагуудын туршлага нь төвлөрсөн удирдлага, алгоритмд суурилсан шударга хуваарилалт нь амьгүй донорын тоог нэмэгдүүлэх үндсэн хөшүүрэг болохыг нотолж байна.

Сэдвийн хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл нь батлагдах нь цаг хугацааны асуудал хэдий ч донор хүлээсэн иргэдийн хувьд найдвар болсон хууль юм. Хуулийн төсөлд “аюулгүй байдлыг хангах” зарчмыг орхигдуулсан нь ДЭМБ-ын удирдамж зарчимтай нийцэхгүй, донор болох насны зааг (18 ба 21 нас) зөрүүтэй туссан зэрэг нь практик хэрэгжилтийн явцад зөрчил үүсгэх эрсдэлтэй тул тодорхой болгох.
- Одоогийн хуулийн зохицуулалт, хуулийн төсөлд тодорхойгүй тусгагдсан нас барагчийн хүсэл зориг болон ар гэрийн шийдвэр зөрчилдөх тохиолдлыг нарийвчлан зохицуулаагүй тул аль нь давуу эрхтэй болохыг хуульд оруулах.
- Ил тод зөвшөөрлийн Opt-in тогтолцоог сайжруулах эсвэл “soft opt-out” хэлбэрт үе шаттай шилжих боломжийг судлах.
- Зүрхний үйл ажиллагаа зогссоны дараах донор (DCD)-ыг хуульчилж, амьгүй донорын тоог нэмэгдүүлэх боломжийг судлах.
- Донорын ач холбогдлыг олон нийтэд сурталчлах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх, гэр бүлд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөө өгөх тогтолцоог хөгжүүлэх, хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээг ашиглан эерэг хандлага төлөвшүүлэх.

Ашигласан эх сурвалж

- Friederike Martin, M. C.-F.-G. (2026). Organ Donation and Transplantation Worldwide: The Global Observatory on Donation and Transplantation 2024 Report. *Global Observatory on Donation and Transplantation Journal*, e655-e656. <https://doi.org/10.1097/TP.0000000000005657>
- Improving self-sufficiency in organ transplantation in Korea. (2021). *Korean Journal of Transplantation*.
- Organ donation: lessons from the Spanish model. (2024). *The Lancet*.
- UDDA. (1981). Uniform Determination of Death Act. Retrieved from: https://lchc.ucsd.edu/cogn_150/Readings/death_act.pdf
- WHO. (2010). WHO GUIDING PRINCIPLES ON HUMAN CELL, TISSUE AND ORGAN TRANSPLANTATION. World Health Organization.
- Донорын тухай хууль. (2018). 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/13160>
- Донорын тухай хууль. (2018). 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/13160>
- Донорын тухай хууль. (2018). 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://doi.org/10.63570/ysnjq688> <https://doi.org/10.63570/ysnjq688>

- Донорын тухай хууль. (2018). 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/13160>
- Донорын тухай хууль. (2018). 15 дугаар зүйлийн 15.2-15.3 дахь хэсгүүд. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/13160>
- Донорын тухай хууль. (2018). 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/13160>
- Донорын тухай хууль. (2018). 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/13160>
- Донорын тухай хууль. (2018). 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэг. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/13160>
- Донорын тухай хууль. (2018). 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/13160>
- Донорын эрэлд. (2024). Retrieved from: eagle.mn: <https://eagle.mn/r/119932>
- Монгол Улсын Үндсэн Хууль. (1992.01.13.). 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн, С.Одонтуяа, Ц.Туваан нар Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай анхдагч хуулийн төслийг өргөн мэдүүллээ. (2024.04.19.). Retrieved from: parliament.mn: <https://www.parliament.mn/nn/62241/>
- Эрүүл мэндийн тухай хууль. (2011). 34 дүгээр зүйл. Retrieved from: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/49>
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай . (2025.03.31.). uih.mn. Retrieved from: Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг: [https://www.uih.mn/h/308/uzel/?tab= https://doi.org/10.63570/mpcd4308](https://www.uih.mn/h/308/uzel/?tab=https://doi.org/10.63570/mpcd4308)
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай. (2025.03.31.). uih.mn. Retrieved from: Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг: <https://www.uih.mn/h/308/uzel/?tab=tosol>
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай. (2025.03.31.). uih.mn. Retrieved from: Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн үзэл баримтлал: <https://www.uih.mn/h/308/uzel/?tab=>
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай. (2025.03.31.). uih.mn. Retrieved from: Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг: <https://www.uih.mn/h/308/uzel/?tab=>
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай. (2025.03.31.). uih.mn. Retrieved from: Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг : <https://www.uih.mn/h/308/uzel/?tab=tosol>
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай. (2025.03.31.). Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг. Retrieved from: United Info Hub: <https://www.uih.mn/h/308> <https://doi.org/10.1158/1557-3265.SABCS24-P2-10-03>